

**ХОТ, ТОСГОНЫ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ХИЙСЭН  
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Улаанбаатар  
2024 он

## Агуулга

<b>Нэг. Ерөнхий мэдээлэл.....</b>	<b>3</b>
<b>Хоёр. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо .....</b>	<b>4</b>
2.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох; .....	4
2.2.Нэг бүрийн зардлыг тооцох; .....	4
2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;.....	4
2.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;.....	4
2.5.Хялбарчлах боломжийг шалгах;.....	4
2.6.Нэмэлт зардлыг тооцох.....	4
<b>Гурав. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо .....</b>	<b>4</b>
3.1.иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;.....	4
3.2.цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох; .....	4
3.3.тоон үзүүлэлтийг тооцох; .....	4
3.4.нийт дүнг тооцож гаргах;.....	4
3.5.хялбарчлах боломжийг шалгах. ....	4
<b>Дөрөв. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан гарснаар улсын төсөвт үүсэх зардлын тооцоо .</b>	<b>4</b>
4.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг /ажил үйлчилгээ/, түүний агуулгыг тодорхойлох.....	5
4.2.Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох ....	7
4.3.Гарах зардлыг тооцох .....	9
4.4.Зардлыг нэгтгэн тооцох .....	13
<b>Дүгнэлт, санал.....</b>	<b>14</b>
<b>Ашигласан эх сурвалж .....</b>	<b>15</b>

## Нэг. Ерөнхий мэдээлэл

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн үйлчлэх хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно.” гэж заасны дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл /цаашид “хуулийн төсөл” гэх/ батлагдсан нөхцөлд түүнийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хуулийн төслийн үр нөлөөг урьдчилан тандан судлах явцад гүйцэтгэх нь тухайн эрх зүйн зохицуулалтын үр нөлөөгөөр хүрэхийг хүссэн үр дүн, түүнийг хэрэгжүүлэх тогтолцоог бий болгоход зарцуулах зардлын харьцааг тогтооход чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэхүү үнэлгээний зорилго нь хуулийн төсөл батлагдсанаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад шинээр үүсэх зардлын ачааллыг урьдчилан тооцож, цаашид гарах зардлыг багасгах санал боловсруулахад оршино.

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход доор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан:

- Иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;<sup>1</sup>
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;<sup>2</sup>
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;<sup>3</sup>
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.<sup>4</sup>

Аргачлалын Ерөнхий зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал (1), хуулийн этгээдийн зардал (2), иргэнд үүсэх зардал (3) гэсэн гурван төрлөөр тооцдог. Харин тус хуулийн төслөөр иргэн болон хуулийн этгээдэд зардал үүсгэх зохицуулалт тусгагдаагүй харин төрийн байгууллагад тодорхой зардал үүсгэхээр тусгасан байх тул энэ хүрээнд үнэлгээг хийсэн.

Хуулийн төслийн зардлыг тооцохдоо бодит статистик болон хугацааг шууд ашиглах боломжгүй тохиолдолд аргачлалын 2.5.2, 4.4.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн адил төстэй ажил, үйлчилгээ байгаа эсэхийг судалж, баримжаалах зэргээр хугацаа, тохиолдлын тоо зэргийг тогтоосон болно.

Түүнчлэн хуулийн төсөл нь анхдагч хуулийн төсөл биш тул дагаж мөрдөж буй 1993 оны Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу үүсч байгаа зардлыг хамааруулахгүйгээр хуулийн төслөөр нэмж зардал үүсгэж болох зохицуулалтыг сонгож зардлын тооцоог гаргасан болно.

<sup>1</sup> Аргачлалын 2.3, 4.3 дахь заалт.

<sup>2</sup> Аргачлалын 2.4.4, 4.4 дэх заалт.

<sup>3</sup> Аргачлалын 4.4.3.1 дэх заалт.

<sup>4</sup> Аргачлалын 2.1, 4.1 дэх заалт.

## **Хоёр. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан гарснаар хуулийн этгээдэд үүсэх зардлын тооцоо**

Энэ хэсэгт хуулийн төсөл батлагдсанаар хуулийн этгээдийн эрхлэх үйл ажиллагаатай холбоотой гүйцэтгэх үүргийн улмаас үүсэх зардлыг мөнгөн дүнгээр тооцоолон гаргана. Ийнхүү үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь үе шаттайгаар тооцоолдог. Үүнд:

- 2.1.Хуулийн этгээдийн гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 2.2.Нэг бүрийн зардлыг тооцох;
- 2.3.Тоон үзүүлэлтийг тооцох;
- 2.4.Нийт зардлын дүнг тооцож гаргах;
- 2.5.Хялбарчлах боломжийг шалгах;
- 2.6.Нэмэлт зардлыг тооцох.

Хуулийн төсөлд хуулийн этгээдэд шинээр үүрэг хүлээлгэсэн, зардал бий болгосон зохицуулалт байхгүй гэж үзсэн тул зардлыг тооцох шаардлагагүй байсан болно.

Учир нь хуулийн төслийн 14.7-д “Энэ хуулийн 14.6-д зааснаас бусад хотын Зөвлөлийн сонгуулийг холбогдох хуулиар зохицуулна.” гэсний дагуу иргэнд үүсэх зардлыг сонгуулийн харилцааг зохицуулах хуулийн төслийг боловсруулах үе шатанд хот, тосгоны зөвлөл, захирагчийн сонгуульд нэр дэвшигчээс гарах зардлыг тооцох шаардлагатай гэж үзлээ.

## **Гурав. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан гарснаар иргэнд үүсэх зардлын тооцоо**

Хуулийн төсөл батлагдсанаар иргэнд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт заасны дагуу дараахь дарааллыг баримтална. Үүнд:

- 3.1.иргэний гүйцэтгэх үүргийг тогтоох;
- 3.2.цаг хугацаа болон гарч болох зардлыг тооцох;
- 3.3.тоон үзүүлэлтийг тооцох;
- 3.4.нийт дүнг тооцож гаргах;
- 3.5.хялбарчлах боломжийг шалгах.

Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгагдсан иргэнд шинээр гүйцэтгэх үүрэг хүлээлгэсэн, зардал бий болгохоор зохицуулалт байхгүй гэж үзсэн.

## **Дөрөв. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдан гарснаар улсын төсөвт үүсэх зардлын тооцоо**

Хуулийн төсөлд төрийн байгууллагад шинэ чиг үүрэг нэмэгдүүлсэн, үүнтэй холбогдуулан тодорхой мөнгөн зардал бий болохоор байх тул төрд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх

аргачлал”-ын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт заасны дагуу дараах үе шаттайгаар тооцлоо. Үүнд:

Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын 4.1-д Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцож гаргах бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- 4.1.төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээг тодорхойлох;
- 4.2.уг чиг үүргийг гүйцэтгэх хүний нөөцийг тодорхойлох;
- 4.3.гарах зардлыг урьдчилан тооцох;
- 4.4.зардлыг нэгтгэн тооцох;
- 4.5.хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулахаар тогтоосон.

#### **4.1.Төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг /ажил үйлчилгээ/, түүний агуулгыг тодорхойлох**

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт “Хотын өөрийн удирдлагын байгууллага нь хотын Зөвлөл мөн” гэж заасан.

#### **25 дугаар зүйл.Хотын Зөвлөлийн гишүүний үйл ажиллагааны баталгаа**

25.1.Зөвлөлийн гишүүн бүрэн эрхийнхээ хугацаанд үнэмлэх, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэх бөгөөд тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг тухайн Зөвлөл батална.

25.2.Зөвлөлийн төсөвт гишүүний цалин, нэмэгдэл, унаа, албан томилолт, бичиг хэргийн зардлыг тусгана.

25.3.Зөвлөлийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь холбогдох байгууллага, албан тушаалтан дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

25.4.Зөвлөлийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд нь аливаа албан тушаалтан, улс төрийн нам, бусад байгууллага хөндлөнгөөс оролцох, үүрэг хүлээлгэхийг хориглоно.

#### **26 дугаар зүйл.Хотын Зөвлөлийн ажлын алба**

26.1.Хотын Зөвлөл ажлын албатай байна.

26.2.Зөвлөлийн ажлын албаны бүтэц, орон тоо, цалингийн санг Засгийн газраас баталсан жишгийн дагуу Зөвлөл тогтооно.

26.3.Хотын Зөвлөлийн нарийн бичгийн дарга нь ажлын албаны дарга байна.

26.4.Зөвлөлийн ажлын алба тогтоосон журмаар үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

## **28 дугаар зүйл. Хотын Захирагч**

28.1. Хотыг өдөр тутамд удирдах, Зөвлөлийн шийдвэрийг хэрэгжүүлэх гүйцэтгэх удирдлага нь хотын Захирагч байна.

28.2. Улсын зэрэглэлтэй хотын Захирагчийг тухайн хотын оршин суугчдаас сонгож, Ерөнхий сайд батламжилна.

28.3. Хуульд өөрөөр заагаагүй бол орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийг тухайн хотын оршин суугчдаас сонгож, аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл улсын зэрэглэлтэй хотын Захирагч батламжилна.

28.4. Улсын зэрэглэлтэй хот нь эдэлбэр газрын хэмжээнд хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, Захирагчид чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түр эзгүйд түүний үүргийг гүйцэтгэх дэд Захирагчтай байна.

28.5. Улсын зэрэглэлтэй хотын дэд Захирагчийг тухайн хотын Захирагчийн саналыг үндэслэн Ерөнхий сайд томилно.

28.6. Захирагчийн бүрэн эрхийн хугацаа дөрвөн жил байна.

28.7. Захирагчийн бүрэн эрх хугацаанаас өмнө дуусгавар болсон бол шинээр сонгогдох, томилогдох Захирагчийн бүрэн эрхийн хугацаа нь өмнөх Захирагчийн бүрэн эрхийн үлдсэн хугацаатай тэнцүү байна.

28.8. Захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албатай байна.

28.9. Хотын Захирагчийн сонгуулийг холбогдох хуулиар зохицуулна.

Энэ шатанд төрийн байгууллагын ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд гүйцэтгэх тоо буюу тохиолдлын тоо, түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг гаргана.

Стандарт үйл ажиллагаа болон зарцуулах хугацааг тодорхойлохдоо Засгийн газрын 59 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралтад заасан хугацааг харгалзан үзэхийн хамт бусад ижил төстэй ажил үйлчилгээг ердийн дундаж албан хаагч гүйцэтгэх хугацааг мөн үндэслэсэн болно.

Тохиолдлын тоог гаргахын тулд доорх Засгийн газрын тогтоолуудыг жишиг болгов. Үүнд:

1. Хотын Зөвлөлийн гишүүний цалинг тооцохдоо Засгийн газрын 2024 оны “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн

тогтоох тухай” 128 дугаар тогтоолын 12 дугаар хавсралтаар батлагдсан “Улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээ”-г баримтлав.

2.Хотын Зөвлөлийн ажлын албаны бүтэц бүрэлдэхүүн, цалин хөлсийг тооцохдоо Засгийн газрын 2021 оны “аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тооны хязгаар тогтоох тухай” 376 дугаар тогтоолыг баримтлав.

3.Хот, тосгоны Захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албаны орон тооны хязгаарыг Засгийн газрын 2024 оны “Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай” 81 дүгээр тогтоол, 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолыг баримтлав.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.4-т Улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүнийг оршин суугчдаас сонгох ба гишүүний тоог доор дурдсанаар тогтооно:

14.4.1.оршин суугчийн тоо нь 200 000 хүртэл бол 21;

14.4.2.оршин суугчийн тоо нь 200 001-ээс дээш бол 25.

Хуулийн төслийн 14 дүгээр зүйлийн 14.5-д Орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүнийг оршин суугчдаас сонгох ба гишүүний тоог доор дурдсанаар тогтооно:

14.5.1.оршин суугчийн тоо нь 50 000 хүртэл бол 11;

14.5.2.оршин суугчийн тоо нь 50 000-аас дээш бол 15.

Дээрх Зөвлөл нь ээлжит хуралдааныг сард нэг удаа хийх<sup>5</sup>, мөн Зөвлөлийн ээлжит бус хуралдааныг нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүйн саналаар эсхүл Зөвлөлийн дарга, Захирагчийн санаачлагаар хуралдуулна<sup>6</sup> гэсний дагуу тохиолдлын тоог хийгдэж байгаа стандарт үйл ажиллагаанаас хамааран жилд **12 удаа** хуралдана гэдгээр тооцоолов.

#### **4.2.Уг чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг тодорхойлох**

Төрийн байгууллагад үүсэх хүний нөөцийн хэрэгцээг дээрх мэдээллийг ашиглан дараах байдлаар гаргадаг.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

---

<sup>5</sup> Хуулийн төслийн 17.6-д

<sup>6</sup> Хуулийн төслийн 17.7-т

1 жил = ажлын 200<sup>7</sup> өдөр  
1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/  
1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 x 8/ = 1600 ажлын цаг буюу /1,600 x 60/ = 96000 минут ажиллана гэсэн үг.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж нэг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөцийн хэрэгцээ буюу ажлын байрны тоо гарна.

### **Одоогийн нөхцөл байдал:**

1.Засгийн газрын 2021 оны “аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тооны хязгаар тогтоох тухай” 376 дугаар тогтоолд зааснаар “Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын төлөөлөгчдийн тооноос хамааруулан Говьсүмбэр аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 8, Архангай, Баян-Өлгий, Булган, Дархан-Уул, Дорноговь, Дорнод, Дундговь, Орхон, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Хэнтий аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 10, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Өвөрхангай, Төв, Увс, Ховд, Хөвсгөл аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албыг 12 хүртэл орон тоотой байх. Аймгийн төвийн болон 6000-аас дээш хүн амтай)-ын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг 4 хүртэл, бусад сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны орон тооны хязгаарыг 3 хүртэл байхаар тооцсон.

Иймд дээрх жишгийг баримтлан Хотын Зөвлөлийн ажлын алба нь 10 орон тоонтой байхаар тооцов. Үүнд:

- Зөвлөлийн нарийн бичгийн дарга бөгөөд нарийн бичгийн дарга – 1;
- Ажлын алба – 9.

Хуулийн төслийн 25 дугаар зүйлийн 25.2-т “Зөвлөлийн төсөвт гишүүний цалин, нэмэгдэл, унаа, албан томилолт, бичиг хэргийн зардлыг тусгана.” Гэж заасан.

Түүнчлэн Хотын Зөвлөлийн гишүүний цалин, нэмэгдлийг тооцохдоо Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын хавсралтын 12 дугаар хавсралтаар баталсан улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг жишиг болгов.

Мөн Хот, тосгоны **ажлын албаны цалингийн санг тогтоохдоо** “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалтыг шинэчлэн батлах тухай” Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол, “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолд тус тус үндэслэж тооцсон болно.

---

<sup>7</sup> Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас, бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.



2.Хот, тосгоны Захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг Засгийн газрын 2024 оны 81 дүгээр тогтоолыг удирдлага болгон дараах байдлаар жишиж тооцлоо.

### 4.3.Гарах зардлыг тооцох

#### 1.Хотын зөвлөлийн гишүүний цалин хөлстэй холбогдуулан гарах зардал:

Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 128 дугаар тогтоолын 12 дугаар хавсралтаар улс төрийн албан тушаал эрхэлдэг зарим албан хаагчийн албан тушаалын цалингийн хэмжээг дараах байдлаар тогтоосон.

(сард, төгрөгөөр)

Албан тушаал	Цалингийн хэмжээ
Улаанбаатар хотын Ерөнхий менежер	2,562,000
Нийслэлийн Засаг даргын орлогч	2,475,000
Аймгийн Засаг даргын орлогч	2,310,000
Дүүргийн Засаг дарга	2,365,000
Дүүргийн Засаг даргын орлогч	2,090,000
Сумын Засаг дарга	2,145,000
Сумын Засаг даргын орлогч	1,870,000
Хорооны Засаг дарга	1,540,000
Багийн Засаг дарга	1,375,000

Энэ тогтоолыг үндэслэл болгон улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүний цалинг нийслэлийн Засаг даргын орлогчийн, орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүний цалинг дүүргийн Засаг даргын цалингийн хэмжээгээр дараах байдлаар дундажаар тооцов.

Улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн 1 гишүүний цалингийн хэмжээ  
 $2,475,000 \text{ төгрөг} * 12 = \mathbf{29,700,000}$  төгрөг байна.

Улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүний цалингийн сан  
 $29,700,000 \text{ төгрөг} * 21 = \mathbf{623,700,000}$  төгрөг

Орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөлийн 1 гишүүний цалингийн хэмжээ  
 $2,365,000 \text{ төгрөг} * 12 = \mathbf{28,380,000}$  төгрөг байна.

Орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүний цалингийн сан  
 $28,380,000 \text{ төгрөг} * 11 = \mathbf{312,180,000}$  төгрөг

2.Хуулийн төслийн 10.2-т “Хотын Зөвлөл, Захирагч нь ажлын албатай байна.” гэж заасны дагуу хотын Зөвлөлийн ажлын албаны ангилал, зэрэглэлийг “Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт батлах тухай” Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоолд заасны дагуу аймаг, сумын

иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын албатай дүйцүүлэн доорх байдлаар тооцов.

Улсын зэрэглэлтэй хотын хувьд:

Зөвлөлийн нарийн бичгийн дарга Зөвлөлийн Ажлын албаны дарга - ТЗ-2;  
Ажлын албаны ажилтан - ТЗ-8.

Орон нутгийн зэрэглэлтэй хотын хувьд:

Зөвлөлийн нарийн бичгийн дарга Зөвлөлийн Ажлын албаны дарга - ТЗ-5;  
Ажлын албаны ажилтан - ТЗ-9.

Хотын Зөвлөлийн ажлын албаны албан тушаалын цалингийн хэмжээг “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар дараах байдлаар тогтооно.

**ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГ, НУТГИЙН ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА БОЛОН  
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ  
АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ**

Албан тушаалын зэрэглэл	Цалингийн хэмжээ (сард, төгрөгөөр)
ТЗ-1	2,440,000
ТЗ-2	2,171,000
ТЗ-3	2,048,000
ТЗ-4	1,933,000
ТЗ-5	1,757,000
ТЗ-6	1,597,000
ТЗ-7	1,452,000
ТЗ-8	1,320,000
ТЗ-9	1,210,000
ТЗ-10	1,100,000

Энэ дагуу тооцоолбол:

Улсын зэрэглэлтэй хотын хувьд:

Зөвлөлийн нарийн бичгийн дарга Зөвлөлийн Ажлын албаны дарга - ТЗ-2;  
 $2,171,000 \text{ төгрөг} * 12 = \mathbf{26,052,000 \text{ төгрөг}}$

Ажлын албаны ажилтан - ТЗ-8.

$1,320,000 \text{ төгрөг} * 12 * 9(\text{ажлын албаны тоо}) = \mathbf{142,560,000 \text{ төгрөг}}$

Нийт: **168,702,000 төгрөг**

Орон нутгийн зэрэглэлтэй хотын хувьд:

Зөвлөлийн нарийн бичгийн дарга Зөвлөлийн Ажлын албаны дарга - ТЗ-5;  
1,757,000 төгрөг \* 12 = **21,084,000 төгрөг**

Ажлын албаны ажилтан - ТЗ-9.

1,210,00 төгрөг \* 12 \* 9(ажлын албаны тоо) = **130,680,00 төгрөг**

Нийт: **151,764,000 төгрөг**

3.Хуулийн төслийн 28.8-д “Захирагч бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий ажлын албатай байна.” гэж заасан. Иймд Хот, тосгоны захирагчийн ажлын албаны цалин урамшууллыг “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолын 3, 12 дугаар хавсралтыг баримтлан дараах байдлаар тооцооллоо.

Нэг.Улсын зэрэглэлтэй хотын хувьд аймагтай адилтган авч үзвэл:

-Хотын Захирагч;  
2,475,000 төгрөг \* 12 = **29,700,000 төгрөг**

-Хотын дэд Захирагч<sup>8</sup>;  
2,310,000 төгрөг \* 12 = **27,720,000 төгрөг**

-Хотын Захирагчийн ажлын албаны дарга–ТЗ-2;  
2,171,000 төгрөг \* 12 = **26,052,000 төгрөг**

-Ажлын албаны орон тоо<sup>9</sup> – ТЗ-7.  
1,452,000 төгрөг \* 12 \* 50 (ажлын албаны орон тоо) = **871,200,000 төгрөг**

Нийт: **954,672,000 төгрөг**

Хоёр.Орон нутгийн зэрэглэлтэй хотын хувьд:

-Хотын Захирагч;  
2,145,000 төгрөг \* 12 = **25,740,000 төгрөг**

-Хотын Захирагчийн ажлын албаны дарга–ТЗ-5;  
1,757,000 төгрөг \* 12 = **21,084,000 төгрөг**

-Ажлын албаны орон тоо<sup>10</sup> – ТЗ-9.  
1,210,000 төгрөг \* 12 \* 30 (ажлын албаны орон тоо) = **435,600,000 төгрөг**

---

<sup>8</sup> 10.4.Улсын зэрэглэлтэй хот нь эдэлбэр газрын хэмжээнд хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, Захирагчид чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, түр эзгүйд түүний үүргийг гүйцэтгэх дэд Захирагчтай байна.

<sup>9</sup> Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолыг үндэслэл болгов.

<sup>10</sup> Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоолыг үндэслэл болгов.

## 2.Бусад нэмэлт, зардлыг тооцох:

Хуулийн төсөлд шинээр зардал үүсэх дараах зохицуулалт байна.

Хуулийн төслийн 27.3-т Зөвлөл нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хуулийн төслийн 29.7-д Хотын Захирагч нь тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, хэвлэмэл хуудастай байна.

Хуулийн төслийн 32.3.7-д Захирагчийн Ажлын алба нь хотын удирдлагын хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах ажлыг хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах;

Хуулийн төслийн 32.5-д Хотын Захирагчийн ажлын албаны дарга эрх хэмжээнийхээ хүрээнд тушаал гаргаж, тогтоосон журмаар үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хуулийн төслийн 29.1.17, 35.1.5-д хот, тосгоны Захирагч нь оршин суугчдын хэрэгцээг хангахад чиглэгдсэн үйлдвэрлэл, үйлчилгээг бий болгоход тусламж дэмжлэг үзүүлэхээр заасан байна.

Дээрх хүснэгтэд дурдсан зардлыг дараах байдлаар тооцож гаргалаа. Үүнд

### **1.Захирагчийн ажлын албаны хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх**

Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоолоор “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга”, “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр”-ийг баталсан.

Төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтын зорилго нь төрийн албан хаагчдад цаг үеийн эрэлт шаардлагад нийцсэн мэдлэг чадварыг тасралтгүй, шуурхай олгоход оршино. Энэ хүрээнд төрийн албан хаагчийн богино хугацааны зорилтот сургалтын агуулгыг цаг үеийн эрэлт шаардлага, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн албаны зөвлөлийн захиалгыг үндэслэн Удирдлагын академи төлөвлөж хэрэгжүүлнэ.

Сургалтын үр дүнд төрийн албан хаагч албан тушаалын чиг үүргээ илүү сайн гүйцэтгэхэд нь шаардагдах тодорхой мэдлэг, ур чадварыг тухай бүр богино хугацаанд эзэмшсэний үндсэн дээр хариуцсан ажил, чиглэлээрээ мэргэшиж ажлын гүйцэтгэл, үр нөлөө нь дээшилнэ.

Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтын зорилго нь төрийн албан хаагчдад эрхэлж байгаа албан тушаалынх нь онцлог, гүйцэтгэж байгаа чиг үүрэг, хариуцсан ажлын шаардлагад нь нийцсэн мэдлэг чадварыг үе шаттайгаар тогтмол хөгжүүлж мэргэшүүлэхэд оршино. Энэ сургалтаар төрийн захиргааны байгууллагын үндсэн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардлагатай төрийн бодлого, бодлого төлөвлөлт, зохицуулалт, захиргаа, хүний нөөц, төрийн

санхүү, төсөв, хяналт-шинжилгээ, үнэлгээ, нутгийн удирдлага, байгууллагын удирдлагын талаарх мэдлэг болон байгууллагын үйл ажиллагааг төлөвлөх, зохион байгуулах, хянах, хамт олныг удирдах, манлайлах, багаар ажиллах, оновчтой шийдвэр гаргах, дүн шинжилгээ хийх, ур чадварын чиглэлтэй байна.

Сургалтын үр дүнд төрийн захиргааны байгууллагын бүтэц, чиг үүргийн дагуу хариуцсан ажил үүргээ үр дүнтэй гүйцэтгэхэд шаардлагатай мэдлэг чадварыг үе шаттайгаар эзэмших талаар тусгасан байдаг.

Энэ хүрээнд хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.1.3 дахь заалт, 37 дугаар зүйлд заасны дагуу хотын Захирагч нь тухайн жилийнхээ төсвийг Хотын Зөвлөлөөр батлуулахдаа Захирагчийн ажлын албаны хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх сургалтад хамрагдах зардлыг батлуулах боломжтой байна.

#### 4.4.Зардлыг нэгтгэн тооцох

Хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх нийт ачаалал зардлыг тооцвол: /жилээр/

№	Зардлын төрөл	Зардлын дүн
1.	Улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүний цалингийн сан	623,700,000
2.	Орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөлийн гишүүний цалингийн сан	312,180,000
3.	Улсын зэрэглэлтэй хотын Зөвлөлийн ажлын албаны зардал	168,702,000
4	Орон нутгийн зэрэглэлтэй хотын Зөвлөлийн ажлын албаны зардал	151,764,000
5.	Улсын зэрэглэлтэй хотын Захирагчийн ажлын албаны зардал	871,200,000
6.	Орон нутгийн зэрэглэлтэй хотын Захирагчийн ажлын албаны зардал	435,600,000
	<b>Нийт зардал</b>	<b>2,563,146,000</b>

Дээрх хүснэгтээс харахад “Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл”-д шинээр тусгасан ажил үйлчилгээг хэрэгжүүлэхэд төрийн байгууллагад **2,563,146,000** төгрөгийн зардал үүсэхээр байна.

Гэвч хуулийн төслийн 5.2-т “Хот байгуулах шийдвэрт тэдгээрийн оноосон нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршил, зааг болон тухайн хотод засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг шилжүүлэх талаар тусгана.” гэж заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэгтэй хамт төсөв, санхүү, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх зохицуулалттай.

Иймд энэ зардал шинээр бүхэлдээ гарна гэж үзэж боломжгүй тул тухайн хотыг байгуулах бүрт уг асуудлыг нарийвчлан тооцох нь зүйтэй байна.

## Дүгнэлт, санал

Хууль тогтоомжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн, 18.1 дэх хэсэгт “Хууль тогтоомжийн төслийг баталснаар тухайн хууль тогтоомжийн хүрээнд хамрагдах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлын тооцоог тухай бүр гаргаж, зардал, үр өгөөжийн харьцааг энэ хуулийн 12.1.4-т заасан аргачлалын дагуу тодорхойлно” гэж заасны дагуу Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар уг хуулийн үйлчлэх хүрээнд хамаарах иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагын үйл ажиллагаанд үүсэх зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”-ыг удирдлага болгон зардлын тооцоог гаргалаа.

Аргачлалын 1 дүгээр зүйлийн 1.5-д заасан журмын дагуу зардлыг иргэнд үүсэх зардал, хуулийн этгээдэд үүсэх зардал, төрийн байгууллагад үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог боловч тус хуулийн төслөөр иргэн, хуулийн этгээдэд зардал үүсгэхээр шинээр зохицуулалт тусгагдаагүй байна.

Судалгааны дүнгээс харахад Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд хийсэн зардлын тооцооны үр дүнг нэгтгэн үзэхэд урьдчилсан байдлаар нэмэлтээр **2,563,146,000** төгрөгийн зардал төрд үүсэхээр байна.

Гэвч хуулийн төслийн 5.2-т “Хот байгуулах шийдвэрт тэдгээрийн оноосон нэр, эдэлбэр газрын хэмжээ, байршил, зааг болон тухайн хотод засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүргийг шилжүүлэх талаар тусгана.” гэж заасны дагуу засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн чиг үүрэгтэй хамт төсөв, санхүү, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн асуудлыг хамтад нь шийдвэрлэх зохицуулалттай.

Иймд энэ зардал шинээр бүхэлдээ гарна гэж үзэж боломжгүй тул тухайн хотыг байгуулах бүрт уг асуудлыг нарийвчлан тооцох нь зүйтэй байна.

---ooOoo---

## Ашигласан эх сурвалж

### Нэг. Эрх зүйн баримт бичиг

1. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл.
2. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлал.
3. Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, 1993 он.
4. Хууль тогтоомжийн тухай хууль 2015 он.
5. Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт. Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал.
6. Засгийн газрын 2021 оны 402 дугаар тогтоолын хавсралт. Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгчийн үйл ажиллагаа, тэдгээрийг чадавхжуулах арга хэмжээний зардлын нийтлэг жишиг, зарцуулах, тайлагнах журам.
7. Засгийн газрын 2021 оны 376 дугаар тогтоол. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны бүтэц, аймаг, сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажлын албаны орон тооны хязгаар тогтоох тухай.
8. Засгийн газрын 2021 оны 360 дугаар тогтоол. Нийслэлийн засаг даргын тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны бүтэц, нийслэл, дүүргийн засаг даргын Тамгын газар, Улаанбаатар хотын захирагчийн ажлын албаны орон тооны хязгаарыг батлах тухай.
9. Засгийн газрын 2022 оны 487 дугаар тогтоол. Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, албан тушаалын жагсаалт батлах тухай.
10. Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоол. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай.
11. Засгийн газрын 2019 оны 299 дүгээр тогтоол. “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын агуулга”, “Төрийн албан хаагчийн богино болон дунд хугацааны сургалтын хөтөлбөр”.

### Хоёр. Ном, гарын авлага, сэтгүүл

1. Хууль, хуулийн төслийн үр нөлөөг тооцох аргачлал. 2013 он. ХЗДХЯ, ГОУХАН.
2. Хууль тогтоомжийн тухай хууль, аргачлал, гарын авлага. 2016 он. ХЗДХЯ 2016 он.

### Гурав. Цахим хуудас:

1. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем [www.legalinfo.mn](http://www.legalinfo.mn)
2. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам. <https://mlsp.gov.mn/content/detail/2072>